



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 680

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 467 дугаар тогтоолын 2.1 дэх тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 49,000,000.05 (дөчин есөн сая төгрөг таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал М.Түмэнжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
123006950  
34-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны 12 дугаар сарын .....-ны өдрийн  
 ..... дугаар тогтоолын хавсралт

"ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН" ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦОТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН  
 ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөгөөр)	Худалдах доод үнэ (төгрөгөөр)
1	Волксваген пассат /Volkswagen, Passat/, 60-02 УНУ улсын дугаартай, суудлын зориулалтын, WVVZZZ3CZER003344 арлын дугаар	2013.12.30	49,000,000.05	49,000,000.05	0	5,000,000.00
Нийт дүн			49,000,000.05 (дөчин есөн сая төгрөг таван мөнгө)	49,000,000.05 (дөчин есөн сая төгрөг таван мөнгө)	0	5,000,000.00 (таван сая)